



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/103

Хужирт сум

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 30 дүгээр зүйлийн 30.1, 52 дугаар зүйлийн 52.7 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны "2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай" 14/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хавсралтанд дурьдсан нэр бүхий 7 иргэнд өвөлжөө хаваржааны доорхи газрыг 60 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрээ байгуулан, гэрчилгээ олгож, газрын улсын бүртгэлд бүртгэхийг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Хужирт сумын Засаг даргын 2020 оны  
06... Дугаар сарын 19-ний өдрийн 4/103  
дугаар захирамжийн хавсралт

Өвөлжөө, хаваржааны доорхи газрыг шинээр эзэмших иргэдийн нэрсийн жагсаалт

д/д	Газар эзэмшигчийн				Эзэмшсэн газрын			
	Эцэг /эх/- ийн нэр	Өөрийн нэр	Регистрийн дугаар	Багийн нэр, дугаар	Хаяг, байршил, газар зүйн нэр	Зориулалт	Хэмжээ /м²/	Газар зүйн солбицол
1	Даваажав	Вандангомбо	ЙС62021916	Уужим 2-р баг	Шандны Хадат нүүр	Өвөлжөө	700	5182578,51 319706,49
2	Даваажав	Вандангомбо	ЙС62021916	Уужим 2-р баг	Шандны Хадат нүүр	Хаваржаа	700	5182552,81 319475,28
3	Ишгэний	Чулуунбаатар	ЙС61071119	Уужим 2-р баг	Бага Лантанз	Өвөлжөө	700	5181310,63 325691,80
4	Сугар	Ганболд	ЙС83030316	Шунхлай 5-р баг	Гуагийн Их бууц	Өвөлжөө	700	5195244,76 334694,81
5	Ёндон	Нэргүй	ЙС83030219	Уужим 2-р баг	Тээлийн Салхитын уулзвар	Өвөлжөө	700	5190961,61 306036,93
6	Рэнчиндорж	Лхагвасүрэн	ТГ59031517	Уужим 2-р баг	Балцруу	Өвөлжөө	700	5191412,9 322687,8
7	Ганхуяг	Бат-Эрдэнэ	ЙС90112238	Шунхлай 5-р баг	Дунд дэл	Өвөлжөө	700	5188370,3 325748,8



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/104

Хужирт сум

Захирамжийн зарим хэсэгт өөрчлөлт оруулж,  
өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн  
байдлаар шилжүүлсэн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах туай хуулийн 3 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020 оны “Захирамжийн зарим хэсэгт өөрчлөлт оруулж, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгах тухай” А/264 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Онцгой комиссын 2020 оны 25 дугаар хурлаар гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгасантай холбогдуулан сумын хэмжээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2020 оны 07 дугаар сарын 15-ны өдөр хүртэл сунгасугай.

2. Дээрх хугацаанд сумын баяр наадмаас бусад уул, овоо тахих, хадагны уралдаан, ургийн баяр, хурдан морины үсэргээ, сунгаа зохион байгуулахыг хориглосугай.

3. Сумын Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн А/95 дугаар захирамжийн 2 дахь заалтын хүнсний дэлгүүр болон архи, согтууруулах ундаа түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй дэлгүүрүүдийн ажиллах цагийн хуваарийг 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 07 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл оройн 08.00-20.00 цаг байхаар хязгаарлалт тогтоож, караоке, баар, цэнгээний газруудын үйл ажиллагааг дээрх хугацаанд түр зогсоосугай.

4. Захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа (Х.Түмэнбаяр), Засаг даргын Тамгын газрын дарга (З.Цэцэгмаа), “Морин спорт” уяачдын холбоонд тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Оюунгэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100207





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/105

Хужирт сум

Ардын хувьсгалын 99 жилийн ойн  
сумын баяр наадмын ажиллагааг зохион  
байгуулах комиссыг батлах тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын хувьсгалын 99 жилийн ойн сумын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Комиссын дарга: Ж.Оюунгэрэл - Засаг даргын орлогч

Гишүүдэд: З.Цэцэгмаа - Засаг даргын Тамгын газрын дарга

Д.Төмөр - Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга

Х.Түмэнбаяр - Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа

О.Долгормаа - Соёлын төвийн эрхлэгч

Г.Оюунмандах - Нягтлан бодогч


Ж. Шижээ - "Хужирт эрдэс баялаг"ОНААТГ-ын дарга

2. Сумын баяр наадмыг зохион байгуулах салбар комиссыг хавсралтаар баталсугай.

3. Баяр наадамын зардлыг Засаг даргын Тамгын газрын Улсын Их баяр наадмын зардлаас зарцуулахыг зөвшөөрсүгэй.

4. Сумын баяр наадмыг 2020 оны 07 дугаар сарын 11-ний өдөр Засгийн газраас баталсан зохих журам, зааврын дагуу зохион байгуулахыг комисс (Ж.Оюунгэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



Сумын Засаг даргын 2009 оны 7 дүгээр  
сарын 21-ны өдрийн 715 дугаар  
захирамжийн хавсралт

Сумын баяр наадмыг зохион байгуулах  
комиссын бүрэлдэхүүн

Бөхийн комисс:

Дарга: Ж.Шижээ - "Хужирт эрдэс баялаг" ОНӨААТГ-ын дарга  
Гишүүд: Д.Мөнхбат- Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан  
мэргэжилтэн  
Ц.Галбадрах - Нийгмийн даатгалын Улсын байцаагч  
Д.Мягмарсүрэн – 4 дүгээр багийн ИНХурлын дарга  
Б.Саранцогт – Дотрын их эмч  
Ж.Отгонбанди- "Хужирт тур" ХХК-ний инженер

Морины комисс:

Дарга: Д.Төмөр - Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга  
Гишүүд: Т.Энхжаргал- Хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн  
Ч.Сонинбаяр- Байгаль хамгаалагч  
О.Алтанчимэг – Байгаль хамгаалагч  
Ц.Ундрахбаяр – Эрүүл мэндийн төвийн эрхлэгч  
С.Самдан – Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн  
Б.Доржсэмбэ – Хүнс, жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо  
хариуцсан мэргэжилтэн  
Д.Жавзандолгор – Нийгмийн бодлогын мэргэжилтэн  
Д.Батбаян – 2 дугаар багийн Засаг дарга  
Д.Галиндэв – 3 дугаар багийн Засаг дарга  
Д.Батбаяр – 4 дүгээр багийн Засаг дарга  
Ц.Амгалан – 6 дугаар багийн Засаг дарга  
Г.Бадамдорж- Жолооч

Соёл, спорт олон нийтийн комисс:

Дарга: О.Долгормаа- Соёлын төвийн эрхлэгч  
Нарийн бичгийн дарга: Б.Лхагвадулам - Номын санч  
Гишүүд: Н.Уранжаргал - Бүжгийн багш  
Т.Баярцэрэн - Биеийн тамир, спортын арга зүйч  
О.Отгонбат - Биеийн тамирын багш  
Ж.Мандах - Эрчим хүчний эрхлэгч

Хэв журмын комисс:

Дарга: Х.Түмэнбаяр - Цагдаагийн тасгийн дарга  
Гишүүд: Э.Бямбацэрэн - Хэсгийн төлөөлөгч  
Н.Мөнх-Эрдэнэ - Замын цагдаагийн зохицуулагч  
Н.Түвшинжаргал - Мөрдөн байцаагч  
Ц.Базарваань - Хэв журмын цагдаа  
Б.Цэрэннадмид - Татварын Улсын байцаагч  
Ч.Даваадулам- Нийгмийн даатгалын Улсын байцаагч

Аж ахуйн комисс:

Дарга: З.Цэцэгма - Засаг даргын Тамгын газрын дарга  
Гишүүд: Д.Уранчимэг- Санхүүгийн албаны дарга  
Л.Цэдэв - Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн  
Ц.Нямдорж - Газрын даамал  
Ё.Даариймаа - Нийгмийн халамжийн сум хариуцсан  
мэргэжилтэн  
Г.Оюунмандах - Нягтлан бодогч  
Т.Элбэгсайхан - Архив, бичиг хэргийн эрхлэгч  
Б.Пагамдулам- 1 дүгээр багийн Засаг дарга  
Ц.Лхамролом - 5 дугаар багийн Засаг дарга  
М.Чимэдрэгзэн- Нярав  
Б.Цэндхорол-Иргэний танхим ажилтан  
Б.Шаравдорж - Жолооч  
Б.Эрдэнэчимэг - Үйлчлэгч  
Д.Галбаатар - Усны тэрэгний жолооч  
Ц. Зундуй - Машинист  
Б. Батсайхан - Машинист

-оОо-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/106

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7<sup>1</sup> дугаар зүйлийн 7<sup>1</sup>.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх “Гэрэлт цамхаг ӨВХУСЗДТГ/202001017” ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Мөнхбат – Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Д.Батбаяр - 4 дүгээр багийн Засаг дарга  
Ц.Нямдорж - Газрын даамал

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээний төслийг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Мөнхбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 02 өдөр

Дугаар /107

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх "Тоглоомын талбай ӨВХУСЗДТГ/202001014" ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Самдан - Мал аж ахуйн асуудал хариуцсан  
мэргэжилтэн

Гишүүд: Д.Батбаяр - 4 дүгээр багийн Засаг дарга  
Ч.Сонинбаяр - Байгаль хамгаалагч

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээний төслийг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (С.Самдан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100213



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/108

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх "Камержуулалт ӨВХУСЗДТГ/202001016" ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Доржсэмбэ - Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Ц.Нямдорж - Газрын даамал

Ч.Сонинбаяр - Байгаль хамгаалагч

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээний төслийг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Доржсэмбэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/109

Хужирт сум

Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

“Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Засаг даргын “Газар өмчлүүлэх тухай” 2005 оны 114 дугаар захирамжийн хавсралтын 5, 2005 оны 88 дугаар захирамжийн хавсралтын 4, 2006 оны 17 дугаар захирамжийн хавсралтын 68, 2005 оны 122 дугаар захирамжийн хавсралтын 6, 2004 оны 51 дугаар захирамжийн хавсралтын 8 дугаарт байгаа 5 өрхийн нэр бүхий 15 иргэний өөрсдийн гаргасан хүсэлт, газар өмчлөх эрх шилжүүлэх гэрээг үндэслэн хавсралтанд заасан нэр бүхий иргэдийн газар өмчлөх эрхийг шилжүүлсүгэй.

2. Газрыг тухайн гэр бүлийн аль нэг гишүүнд өмчлүүлж, бусад гишүүдэд газрыг хууль тогтоомжид заасны дагуу нэг удаа үнэгүй өмчлүүлэх ажлыг зохион байгуулахыг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



Хужирт сумын Засаг даргын 2020 оны  
 07 дугаар сарын 03 ны өдрийн 4/09 дугаар  
 захирамжийн хавсралт

Газар өмчлөх эрхээ шилжүүлсэн иргэдийн нэрсийн жагсаалт

Д/д	Өмчлөгчийн								Газрын		
	Овог	Эцэг /эх/- ийн нэр	Өөрийн нэр	Оршин суугаа хаяг	Регистр	16 нас хүрээгүй өмчлөгчийн гэрчилгээний дугаар	Урьд нь газар өмчлүүлсэн захирамжийн дугаар, огноо	Байршил	Хэмжээ /м2/	Газрын үнэ /мян.төг/	
А	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
5	1	Цэрэндаш	Жигжид	Цэрмаа	5-р баг	ЙС70062245		2005.11.03 114	5-р баг	932	671040
	2	Бал	Эмээл	Эрдэнэбаяр	5-р баг	ЙС98051538					
	3	Бал	Эмээл	Цэндсүрэн	5-р баг	ЙС02292807					
4	4	Наран	Баянменх	Санчир	4-р баг	ЙС01312417		2005.09.12 88	4-р баг	1540.4	1109088
68	5	Шарнууд	Диймаа	Дулам	5-р баг	ЙС67042461		2006.02.28 17	5-р баг	2266	1631520
	6	Боржигон	Ганбаатар	Базар	5-р баг	ЙС91030514					
6	7	Шарав	Бийлхүү	Цэцэг-Эрдэнэ	1-р баг	ЙС77121800		2005.12.01 122	5-р баг 372 тоот	1059	762480
	8	Хув	Дэмбэрэл	Дуламсүрэн	6-р баг	ЙС98112128					



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/110

Хужирт сум

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрчим хүчний салбарын 98 жил, Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ний 40 жилийн ойг тохиолдуулан үр бүтээлтэй ажиллаж байгаа сумын Байцаагч монтер Нацагдоржийн Өлзийбатыг “Сумын Засаг даргын хүндэт өргөмжлөл”-өөр шагнасугай.

2. Дээрх шагналд дагалдах 30000 (гучин мянга) төгрөгийг сумын Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/111

Хужирт сум

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт  
хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн  
хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020 оны "Захирамжийн зарим хэсэгт өөрчлөлт оруулж, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгах тухай" А/306 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Онцгой комиссын 2020 оны 25 дугаар хурлаар гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгасантай холбогдуулан сумын хэмжээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасугай.

2. Сумын Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/95 дугаар захирамжийн 3 дахь заалтын хүнсний дэлгүүр болон архи, согтууруулах ундаа түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй дэлгүүрүүдийн ажиллах цагийн хуваарийг 2020 оны 07 дугаар сарын 15-ны өдрөөс 07 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл оройн 09.00-22.00 цаг байхаар хязгаарлалт тогтоож, караоке, баар, цэнгээний газруудын үйл ажиллагааг дээрх хугацаанд түр зогсоосугай.

3. Хурдан морины уралдаан, уул овооны тахилга, ой тэмдэглэх, ургийн баяр, хадагны уралдаан, анги хамт олны уулзалт зэрэг олон нийтийг хамрасан арга хэмжээ зохион байгуулахыг хориглосугай.

4. Захирамжийг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Оюунгэрэл), Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа (Х.Түмэнбаяр), Засаг даргын Тамгын газрын дарга (З.Цэцэгмаа) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100221





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/112

Хужирт сум

Дуудлага худалдаа явуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 1.2 дахь заалт, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” 14/07 дугаар тогтоолыг тус тус үнэдслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын нутагт газар эзэмшүүлэх дуудлага худалдаагаар эзэмшүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалт, эзэмшүүлэх хугацааг нэгдүгээр, эзэмшүүлэх газрын дуудлага худалдаа явуулах өдөр, анхны үнэ, дэнчингийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дуудлага худалдаа явагдах зар мэдээг хуулийн дагуу иргэдэд мэдээлэхийг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Хужирт сумын Засаг даргын 2020 оны  
07 дугаар сарын 24 өдрийн 111 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

Д/д	Дуудлага худалдаагаар шинээр эзэмшүүлэх газар			Эзэмшүүлэх хугацаа /Жил/
	Байршил	Талбайн хэмжээ /м.квд/	Зориулалт	
1	Шивээт 4-р баг, Л.Зоригийн эзэмшлийн газрын зүүн хойд талд	500 м <sup>2</sup>	Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ	30
2	Шунхлай 5-р баг, Гуа хороолол 75 хүүхдийн цэцэрлэгийн баруун талд	600 м <sup>2</sup>	Шинээр уурын зуух барих	30
3	Шивээт 4 дүгээр баг АЖУДС-н урд	2873 м <sup>2</sup>	Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ	30
4	Шунхлай 5-р баг, "Хужирт рашаан сувилал" ХХК-ний хойд талд	5637 м <sup>2</sup>	Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ	30
5	Шивээт 4-р баг, иргэн Н.Батзаяагийн эзэмшлийн газрын баруун талд	2362 м <sup>2</sup>	Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ	30
6	Шивээт 4-р баг, иргэн Ч.Баянмөнхийн эзэмшлийн газрын баруун талд	826 м <sup>2</sup>	Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ	30
7	Шивээт 4-р баг, "Тө-Ба-Сэ" ХХК-н зүүн урд талд	302 м <sup>2</sup>	Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ	30
8	Шунхлай 5-р баг, "Ананд хужирт" ХХК-ний баруун талд	220 м <sup>2</sup>	Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ	30
9	Шунхлай 5-р баг, "Элма хужирт" ХХК-ний Зүүн урд талд	1214 м <sup>2</sup>	Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ	30



Хужирт сумын Засаг даргын 2020 оны  
07 дугаар сарын 21 өдрийн // дугаар  
Захирамжийн хоёрдугаар хавсралт

Д/д	Дуудлага худалдаагаар шинээр эзэмшүүлэх газрын				Дуудлага худалдаа эхлэх хугацаа
	Байршил	Дуудлага худалдааны анхны үнэ /төг/	Дэнчингийн хэмжээ /төг/	Дуудлага худалдаанд ороцогчдыг бүртгэх хугацаа	
1	Шивээт 4-р баг, Л.Зоригийн эзэмшлийн газрын зүүн хойд талд	400000	40000	2020-09-10 ны өдрөөс 2020-09-15 ны өдрийн 11 <sup>00</sup> цаг хүртэл	2020-09-15 ны өдрийн 11 <sup>30</sup> цагт
2	Шунхлай 5-р баг, Гуа хороолол 75 хүүхдийн цэцэрлэгийн баруун талд	480000	48000	2020-09-10 ны өдрөөс 2020-09-15 ны өдрийн 15 <sup>00</sup> цаг хүртэл	2020-09-15 ны өдрийн 15 <sup>30</sup> цагт
3	Шивээт 4-р баг АЖУДС-н урд	2298400	229840	2020-09-11 ний өдрөөс 2020-09-16 ны өдрийн 11 <sup>00</sup> цаг хүртэл	2020-09-16 ны өдрийн 11 <sup>30</sup> цагт
4	Шунхлай 5-р баг, "Хужирт рашаан сувилал" ХХК-н хойд талд	4509600	450960	2020-09-11 ний өдрөөс 2020-09-16 ны өдрийн 15 <sup>00</sup> цаг хүртэл	2020-09-16 ны өдрийн 15 <sup>30</sup> цагт
5	Шивээт 4-р баг, иргэн Н.Батзаяагийн эзэмшлийн газрын баруун талд	1889600	188960	2020-09-14 ний өдрөөс 2020-09-17 ны өдрийн 11 <sup>00</sup> цаг хүртэл	2020-09-17 ны өдрийн 11 <sup>30</sup> цагт
6	Шивээт 4-р баг, иргэн Ч.Баянмөнхийн эзэмшлийн газрын баруун талд	660800	66080	2020-09-14 ний өдрөөс 2020-09-17 ны өдрийн 15 <sup>00</sup> цаг хүртэл	2020-09-17 ны өдрийн 15 <sup>30</sup> цагт
7	Шивээт 4-р баг, "Тө-Ба-Сэ" ХХК-н зүүн урд талд	241600	24160	2020-09-15 ны өдрөөс 2020-09-18 ны өдрийн 10 <sup>00</sup> цаг хүртэл	2020-09-18 ны өдрийн 10 <sup>30</sup> цагт
8	Шунхлай 5-р баг, "Ананд хужирт" ХХК-н баруун талд	176000	17600	2020-09-15 ны өдрөөс 2020-09-18 ны өдрийн 14 <sup>00</sup> цаг хүртэл	2020-09-18 ны өдрийн 14 <sup>30</sup> цагт
9	Шунхлай 5-р баг, Элма хужирт" ХХК-н Зүүн урд талд	971200	97120	2020-09-15 ны өдрөөс 2020-09-18 ны өдрийн 16 <sup>00</sup> цаг хүртэл	2020-09-18 ны өдрийн 16 <sup>30</sup> цагт





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/113

Хужирт сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ажлын хэсгийн 2020 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу "Гэрэлтүүлэг засвар ӨВХУСЗДТГ/202001020" ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг 19000000 (арван есөн сая) төгрөгөөр Ж.Мандах ахлагчтай "Эрчим" бүлгээр гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Дээрх шалгарсан бүлэгтэй гэрээ байгуулж, ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Цэцэгмаа)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/114

Хужирт сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ажлын хэсгийн 2020 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу "Гэрэлт цамхаг ӨВХУСЗДТГ/202001017" ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг 16000000 (арван зургаан сая) төгрөгөөр Т.Буянзаяа ахлагчтай "Тэмүүлэл" бүлгээр гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Дээрх шалгарсан бүлэгтэй гэрээ байгуулж, ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Цэцэгмаа)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/115

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх "Тоглоомын талбай ӨВХУСЗДТГ/202001014" ажлыг хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Цэдэв - Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн  
Гишүүд: Т.Энхжаргал - Хөдөлмөрийн асуудал хариуцсан  
мэргэжилтэн  
М.Чимэдрэгзэн - Нярав

2. Дээрх ажлыг техникийн тодорхойлолт, гэрээний дагуу хүлээж авахыг ажлын хэсэг (Л.Цэдэв)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 04 өдөр

Дугаар А/116

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх “Ногоон байгууламж нэмэгдүүлэх” ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Бямбасүрэн - Байгаль орчны асуудал хариуцсан  
мэргэжилтэн

Гишүүд: Д.Батбаяр - 4 дүгээр багийн Засаг дарга  
Ч.Сонинбаяр - Байгаль хамгаалагч

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээний төслийг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Бямбасүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/117

Хужирт сум

Тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 6 дугаар багийн иргэн Адьяагийн Амар-Энхэд 100000 (нэг зуун мянган) төгрөгийн тусламжийг хавсралтаар үзүүлсүгэй.
2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/118

Хужирт сум

Бруцеллёз өвчнөөс урьдчилан  
сэргийлэх вакцинжуулалтын ажлыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 (а), Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 3.3.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулахыг “Гонир манал”, “Гуахарз” мал эмнэлэг үржлийн нэгжийн эмч (Ш.Байгальмаа), (Ц.Батдэлгэр) нарт тус тус даалгасугай.
2. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, тарилгын акт жагсаалтанд дүгнэлт гарган тайлан мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлэхийг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Т.Сундуйбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/119

Хужирт сум

Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны  
өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “а”дахь заалт, Засгийн газрын 2020 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 19 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай” А/338 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг төлөвлөгөөний дагуу сайтар зохион байгуулж, биелэлтийн үр дүнг 2020 оны 10 дугаар сарын 10-ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Ж.Оюунгэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/120

Хужирт сум


Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

“Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Засаг даргын “Газар өмчлүүлэх тухай” 2005 оны 22 дугаар захирамжийн хавсралтын 17, 2008 оны 15 дугаар захирамжийн хавсралтын 31 дүгээрт байгаа 2 өрхийн нэр бүхий 6 иргэний өөрсдийн гаргасан хүсэлт, газар өмчлөх эрх шилжүүлэх гэрээг үндэслэн хавсралтанд заасан нэр бүхий иргэдийн газар өмчлөх эрхийг шилжүүлсүгэй.

2. Газрыг тухайн гэр бүлийн аль нэг гишүүнд өмчлүүлж, бусад гишүүдэд газрыг хууль тогтоомжид заасны дагуу нэг удаа үнэгүй өмчлүүлэх ажлыг зохион байгуулахыг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Хужирт сумын Засаг даргын 2020 оны  
09 дугаар сарын 02-ны өдрийн захирамжийн хавсралт

Газар өмчлөх эрхээ шилжүүлсэн иргэдийн нэрсийн жагсаалт

Өрхийн дугаар	Д/д	Өмчлөгчийн							Газрын			
		Овог	Эцэг /эх/-ийн нэр	Өөрийн нэр	Оршин суугаа хаяг	Регистр	16 нас хүрээгүй өмчлөгчийн гэрчилгээний дугаар	Урьд нь газар өмчлүүлсэн захирамжийн дугаар, огноо	Байршил	Хэмжээ /м2/	Газрын үнэ /Мян.төг/	
A	0	1	2	3	4	5	6	7	8	9	10	
17	1	Сүнчиг	Гарамбазар	Төгөлдөр	Улаанбаатар	ЙР01282509						
		Сүнчиг	Гарамбазар	Даваацэрэн	Улаанбаатар	УШ95073107			2005.02.28	22	4-р баг	16740
		Сүнчиг	Гарамбазар	Даваасүрэн	Улаанбаатар	УШ95073121						
31	4	Мижид	Рагчаасүрэн	Ундармаа	5-р баг	ЙС96051907		2008.01.31	15	4-р баг	22360	





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/121

Хужирт сум

Тарваган тахал өвчнөөс урьдчилан  
сэргийлэх, хянах ажлыг эрчимжүүлэх  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (в), Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Тарваган тахал өвчний дэгдэлтийн бэлэн байдлыг хангах ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай.
2. Орон нутгийн онцлогт тохирсон төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулан ажиллахыг ажлын хэсэг (Ж.Оюунгэрэл)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2020 оны 09 дүгээр  
сарын 03 -ны өдрийн 7/21 дугаар  
захирамжийн хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга: Ж.Оюунгэрэл - Засаг даргын Орлогч  
Нарийн бичгийн дарга: Т.Сундуйбаяр - Тархвар зүйч  
Гишүүд: Ц.Ундрахбаяр-Эрүүл мэндийн төвийн дарга  
Б.Бямбасүрэн-Байгаль орчны хяналтын Улсын байцаагч  
Х.Түмэнбаяр-Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа  
Н.Баянсан-Аврах бүлгийн дарга  
Ч.Сонинбаяр-Байгаль хамгаалагч  
Б.Пагамдулам-1 дүгээр багийн Засаг дарга  
Д.Батбаян-2 дугаар багийн Засаг дарга  
Д.Галиндэв-3 дугаар багийн Засаг дарга  
Д.Батбаяр-4 дүгээр багийн Засаг дарга  
Ц.Лхамролом-5 дугаар багийн Засаг дарга  
Ц.Амгалан-6 дугаар багийн Засаг дарга



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/122

Хужирт сум

Дуудлага худалдаа явуулах ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Л.Цэдэв - Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн  
Дуудлага худалдааны хөтлөгч: Ц.Нямдорж - Газрын даамал  
Тэмдэглэл хөтлөгч: Д.Мөнхбат - Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Ажлын хэсгийн дарга (Л.Цэдэв)-д ДААЛГАХ нь:

а. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 208 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлал”-ын дагуу тогтоож, өсгөн хэлэх үнийн доод хязгаарыг 100 000 (нэг зуун мянган) төгрөг байхаар тус тус тогтоон, зохих журмын дагуу дуудлага худалдааг зохион байгуулах.

б. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/123

Хужирт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
бусдад шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг үндэслэн  
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар, Баянгол, 12 дугаар хороо, 6 дугаар бичил хороолол, Хасбаатар гудамж ба байр, 28 хаягт оршин суух Самданцоодолын Ганбаяр (ШД87051894) нь өөрийн эзэмшлийн Өвөрхангай, Хужирт сум, 5 дугаар баг Гуа-68 тоотод байрлах 000044584 тоот гэрчилгээний дугаартай, 6211003011 тоот нэгж талбарын дугаартай "Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор"-ын зориулалттай 2000.0 м2 газрыг тус сумын 4 дүгээр баг, Шивээт 6 гудамж, 16 тоот хаягт оршин суух Дашнямын Мөнхбатын (ЙС82072556) эзэмшилд шилжүүлсэн тул дээрх газрыг Д.Мөнхбатад (ЙС82072556) "Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор"-ын зориулалтаар 26 жил 5 сарын хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

3. Дээрх захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/70 дугаар захирамжийг хүчингүйд тооцугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/124

Хужирт сум

Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн  
хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах туай хуулийн 3 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 103 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Засгийн газрын 2020 оны 103 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгасантай холбогдуулан сумын хэмжээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгасугай.

2. Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн хувийн горимд шилжүүлэхтэй холбогдуулан халдвараас урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, Ерөнхий боловсролын сургуулийн захирал, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

